

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2021/06/11 **Дуусах хугацаа:** 2021/06/25

Ажил эхлэх хугацаа: 2021/07 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Багш, ажилтан, оюутны эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тандах, судлах, хянах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- Сургуулийн хичээлийн байр, цайны газар болон оюутны дотуур байрны цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллана.
- Багш, ажилтан, оюутнуудад эрүүл мэндийн сургалт, семинар зохион байгуулах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх хэвшилд дадалжуулна.

Тавигдах шаардлага:

- Анагаах ухааны болон сувилахуйн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай;
- Харилцааны өндөр соёлтой, багаар болон бие даан бүтээлч санаачилгатай ажиллах чадвартай;
- Хариуцлага хүлээх чадвартай;
- Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, соёл, дэг журмыг сахин ажиллах чадвартай байх;
- Мэдээлэл боловсруулах, судалгаа хийж, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулах, тайлан боловсруулах чадвартай байх;
- Компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн байх;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар /CV/
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон мэргэжлийн үйл ажилллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та тус ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж байгаа бол бичиг баримтаа зарласан хугацаанд багтаан recruitment@gmit.edu.mn хаягаар цахим хэлбэрээр бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.